

**“АЛСЫН ХАРАА -2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН  
2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

2023 оны 06 дугаар сарын 02

Улаанбаатар хот

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь /хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар/
				Он	Түвшин		
1	2	3	4	5	6	7	8
Зорилт 2.7.Монгол хүний удмын санг хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлж, монгол хүний хөгжлийг дэмжинэ.							
2.7.3.	Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаачдын тооны зохист түвшнийг хадгалж, бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно.	0.0	Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийн хөгжүүлэлт	2022	Шинэчлэн хөгжүүлэх программ хангамжийн тоо-1	Үйл ажиллагаа хэвийн явагддаг болсон байна.	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 483 дугаар тогтоолоор “Гадаадын иргэн Монгол Улсад оршин суух болон түүнийг бүртгэх журам”, мөн 484 дүгээр тогтоолоор “Монгол Улсын виз олгох журам”-д тус тус нэмэлт, өөрчлөлт оруулснаар гадаадын иргэний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох эрх зүй, суурь нөхцөлийг илүү сайжруулан ажиллаж байна.  “Гадаадын иргэний бүртгэл мэдээллийн нэгдсэн систем” (ISM) дэх мэдээллийн санг “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системд хөрвүүлэх программыг хөгжүүлж, 05 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар үйл ажиллагааны бэлэн байдлыг хангалаа. Визийн зөвшөөрлийн хүсэлт илгээх, хүлээн авах, төлбөрийн модулийг хэсэгчлэн гүйцэтгэж, хүсэлтийг хуваарилах, шийдвэрлэх, ажилтны хандах эрх үүсгэх тохиргоог системд оруулан төлөвлөгөөний дагуу программ хангамжийг шат дараатай хөгжүүлж байна.
Үнэлгээ							30

--oo0oo--